

УМАРД СОЛОНГОСЫН ГАДААД БОДЛОГО ДАХЬ УЛС ТӨРИЙН РЕАЛИЗМ

Б.Батсайхан*

Abstract: *Kim Il Sung's Juche policy, which was in the national interest of the DPRK to unite the South by the superiority of military force, was similar in some sense to the policy of political realism. And Kim Jong-Il's policy was to maintain power through military force and ideology. The nuclear policy of the DPRK in some sense confirms Waltz 's theory about protection of safety, but the grown weak national economy long will not sustain all the time the strengthened economic sanctions of the UN and American pressure.*

Key words: *Political realism, power, national interest, Juche ideology, self-reliance(자주성), the Songun politics, Kang song dae kuk, neorealism, The North Korean nuclear policy*

Улс төрийн реализмын онол дэлхийн хоёрдугаар дайны дараа барууны улс орнууд, ялангуяа АНУ-д ихэд дэлгэрчээ. Улс төрийн реализмын гол үндэслэл нь эрх мэдэл, хүчний төлөө тэмцэл юм. Улс төрийн реализмын онолын гол төлөөлөгчөөр Ганс Моргентаяу, Реймон Арон, мөн АНУ-ын ТНБ-ийн дарга асан Г.Киссинжер нарыг нэрлэж болно. Ялангуяа Г.Моргентау-ийн “Hans J. Morgentau. Politics Among Nations. The Struggle for Power and Peace.” (Үндэстэн хоорондын улс төрийн харилцаа. Засгийн эрх ба энх тайвны төлөө тэмцэл) ном улс төрийн реализмын үндсэн сурах бичиг болсон. Моргентау бичихдээ” олон улсын бодлого, ер нь бүхий л бодлого эрх мэдлийн төлөө тэмцэл.” гэжээ.¹ Түүнчлэн гадаад бодлогын зорилт нь тодорхой хүчээр дэмжигдсэн үндэсний ашиг сонирхол гэсэн үндсэн үзэл санаатай ажээ. Моргентау улс төрийн реализмын 6 зарчмыг тодорхойлсон. Эдгээр зарчмуудын гол агуулгыг товчоор тодорхойлохыг оролдвол,

1. Хүний мөн чанар өөрчлөгдөхгүй, нийгэм бүхэлдээ хүний мөн чанарт тулгуурласан бодит хуульд захирагддаг тул улс төрийн шударга, ёс суртахуунтай дэг журам тогтоох боломж нь хязгаарлагдмал.
2. Үндэсний эрх ашиг нь эрх мэдэл хүч чадлаар тодорхойлогдоно.
3. Эрх мэдлийн ойлголт дахь эрх ашиг нь хэдийгээр өөрчлөгддөг ч объектив шинж чанартай. Эрх ашгийн ойлголт улс төрийн мөн чанарыг илэрхийлэх

* МУИС, ОУХНУС-ийн ОУХ-ны тэнхимийн докторант

¹ Hans J. Morgentau. Politics Among Nations. The Struggle for Power and Peace. Third Edition. N.Y., 1961 (перевод М. Старкова). 1961. P. 27).

- бөгөөд тодорхой нөхцөл, газар, цагаас үл хамаарна.
4. Улс төрийн бодлогын ёс зүйн ач холбогдлыг авч үзэж, улс төрийн үйл ажиллагаанд үнэмлэхүй ёс суртахууны зарчмыг тавьж болохгүй.
 5. Тухайн үндэсний ёс суртахууныг адилтгах болон үнэмлэхүй ёс суртахууны хууль байхгүй.
 6. Улс төрийн реализм бусад онолын дэг сургуулиудаас үндэсний хүчин чадалд улс төр яаж нөлөөлдгийг судалдгаараа өөр г.м. ажээ.

БНАСАУ 1948 онд ЗХУ-ын тусламжтай социалист улс болон тогтнохдоо анхлан марксизм-ленинизм-г улс төрийн бодлогынхоо гол онол болгов. Маркс, олон улсын харилцааг авч үзэхдээ, олон улсын харилцаа нь хэмжээний хувьд л гэхээс нийгмийн дотоод харилцаанаас ялгагдах зүйлгүй гэж үзжээ.² Энэ нь олон улсын харилцааг нийгмийн доторхи хөрөнгөтөн, ажилчин ангийн хоорондын тэмцэлтэй адилтгасан хэрэг аж. Марксизм-ленинизмын онолоор, олон улсын харилцааны гол тоглогч нь дэлхийн хөрөнгөтөн ба олон улсын ажилчин анги, улс бол хоёрдогч гэж үзжээ. Умард Солонгос ч энэхүү онолын дагуу дэлхийн социалист лагерьт багтаж, пролетарийн диктатурыг тогтоож, олон улсын империализмыг эсэргүүцэх бодлого явуулсан. Гэхдээ Ким Ир Сен-ий гадаад бодлогын хамгийн гол зорилго нь Өмнөдийг(Өмнөд Солонгос) хүчээр нэгтгэхэд оршиж байв. 1950 оны солонгосын дайнд нэг талаас Умард Солонгос, БНХАУ нөгөө талаас Өмнөд Солонгос, АНУ-ын цэргийн тулгарал болж, үр дүнд нь Өмнөд Солонгос АНУ-ын хамгаалалтанд орж, америкийн цэрэг солонгосын хойгт байршив. ЗХУ солонгосын дайнд хэдийгээр цэргийн техник хэрэгсэл, командлалын тусламж үзүүлсэн ч цэргийн шууд дэмжлэг үзүүлэхийг хүссэн Ким Ир Сен-ий удаа дараагийн /1950,1972/ хүсэлтэд татгалзсан хариу өгсөн юм. Түүнчлэн 1956 оноос эхэлсэн ЗХУ ба БНХАУ-ын хагаралд БНАСАУ аль ч талыг дэмжилгүй дундыг баримтлах бодлого явуулахад хүрэв.³ Ким Ир Сен ЗХУ-ын “нэг хүнийг тахин шүтэх”, Хятадын “соёлын хувьсгал”-ын алийг нь ч дэмжээгүй ч ЗХУ-ын зүгээс БНАСАУ-ыг Хятадын талд орсон гэсэн үндэслэлээр цэрэг, санхүүгийн тусламжаа эрс багасгасан, харин Мао Цзедун соёлын хувьсгалыг дэмжээгүй хэмээн Ким Ир Сен-ийг ревизионист гэж буруутгаж байсан ажээ.

Энэ нөхцөлд, 1955 онд Ким Ир Сен өөрийн орны уламжлал, түүхэнд үндэслэгдсэн гэх “Жүчэй”-н үзэл баримтлалыг гарган тавьснаар⁴ УС-ыг бусад социалист улсуудаас ялгаруулсан юм. Улмаар 1972 оны үндсэн хуулиндаа: “БНАСАУ нь марксизм-ленинизмыг өөрийн улсынхаа бодит байдалд бүтээлчээр авч хэрэглэн СХН-ын “Жүчэй”-н⁵ үзэл баримтлалыг өөрийн үйл ажиллагааны чиглэл болгоно”⁶ гэж тунхаглажээ.

² Маркс и Энгельс. Сочинения. 2-ое издание. Т. 12. С. 735-736

³ Dae-Sook Suh, *Kim IL Sung, The North Korean Leader*(NewYork: Columbia Univesity Press, 1988), p. 176.

⁴ Ким Ир Сен. Об искоренении догматизма и формализма в идеологической работе и об установлении чучхе: Речь перед работниками партийной пропаганды и агитации 28 декабря 1955 года / Ким Ир Сен. - Пхеньян: Инъязиздат, 1973.

⁵ Ким Ир Сений боловсруулсан “Өөрөө өөртөө эзэн байх” гэсэн гол утга санаатай улс төрийн онол.

⁶ БНАСАУ-ын УХ, I бүлгийн 4-р зүйл, 1972 он \북한 자료 센터, 통일북한 정보, 북한법령, unikorea.go.kr)

“Жүчэй”-н үзэл баримтлал⁷ нь гадаад бодлогодоо, бие даах /자주성/, өөрийнхөө хүчинд тулгуурлах, бусдыг сохроор дагахгүй байх үзэл /반사대주의/⁸ гэсэн томъёоллыг онцгойлон гаргаж тавихын хамт, бүх улсын ард түмэн өөрийн тусгаар тогтнол, бие даасан байдлыг хангах, империализмын эсрэг тэмцэх, түүнчлэн бусад ард түмнийг хүч чадлаараа далайлгах гэсэн аливаа гадаад хүчний давамгайллын эсрэг тэмцэх ёстой гэсэн үзэл баримтлалыг багтаажээ.

1966 оны “Нодун Син Мүн”-ий тэргүүн өгүүлэлд, “...манай нам өнгөрсөн үе шигээ цаашдаа дотоод гадаад үйл ажиллагаандаа тусгаар байх бодлогыг хатуу баримталж, бие даах чиглэлийг хэрэгжүүлэх болно” гэжээ.⁹ Бие даах бодлогын томъёололдоо, 1962 онд “батлан хамгаалахдаа бие даах”, 1966 онд “гадаад бодлогодоо бие даах” гэсэн зарчмыг тусгасан байна. БНАСАУ-ыг “Жүчэй”-н онолын үзэл баримтлалын дагуу, “улс төр, эдийн засгийн хувьд тусгаар, өөрийгөө хамгаалж чадах, ард түмний ашиг сонирхолд үйлчлэх, үндэсний уламжлалд тулгуурласан социалист улс” гэж тодорхойлжээ.¹⁰

Ийнхүү Ким Ир Сен Өмнөдийг нэгтгэх гадаад бодлогодоо том хөршүүд, ялангуяа ЗХУ-ын цэрэг-зэвсгийн шууд тусламж, дэмжлэгт найдахын оронд бие даах, өөртөө эзэн байх ”Жүчэй”-н онолыг гарган тавьж, хэрэгжүүлэхийг оролдсон байна. Гэвч Ким Ир Сен-ий Өмнөдөөсөө хүчирхэг болох гэсэн бодлого 1980-аад оны сүүлч хүртэл үргэлжилсэн ч 1990-ээд онд социалист систем задран унаснаар өөр агуулгатай болжээ.

1990-ээд оноос Ким Жон Ир төрийн эрхэнд гармагцаа “Жүчэй”-н үзэл баримтлалыг 1998 онд “Хүчирхэг, хөгжилтэй их улсыг байгуулах” /Кан Сон Дэ Гүк/¹¹ 2003 онд “Цэргийг түрүүнд тавих” /Сонгүн/¹² бодлогоор нэмэлт хийв. Ким Жон Ир-ийн “Цэргийг түрүүнд тавих” үзэл баримтлал нь “цэргийн хэргийг түрүүнд тавих, цэргийн хүчин чадлаа бэхжүүлэхэд бүх хүчин чадлаа чиглүүлэх ө.х. улсынхаа батлан хамгаалалахад гол анхаарлаа хандуулах” бодлого байв.¹³ Үүнд, улсаа цэргийн тулгарал тохиолдсон үед “хүн хүчний ялалтын баталгааг” хангахын тулд орчин үеийн довтолгооны болон хамгаалалтын хэрэгслээр хангагдсан “цэргийн хүчирхэг гүрэн” болгох, армийн цэргийн бэлэн байдлыг дээшлүүлж, бүх ард түмнийг зэвэсэгжүүлэх, бүх улс орныг “халдашгүй бат бэх цайз” болгох ёстой гэж үзжээ.¹⁴

Ким Жон Ир-ийн “цэргийг түрүүнд тавих” бодлого, “хүчирхэг, хөгжилтэй их улсыг байгуулах” үзэл баримтлалууд нь урьдын Өмнөдийгөө цэргийн хүчээр

⁷ Жүчэй-эртний дорнодахины гүн ухааны нэр томъёо, жү-эзэн, гол: чэй-бие, хүн. Орчуулвал -Өөрөө өөртөө эзэн. Ким Ир Сен, Ким Жон Ир нар өөрийн орны үзэл баримтлал болгосон.

⁸ Өөрийн бодол, санаагүй хүчтэй улс, хүнийг дагахын эсрэг үзэл

⁹ “자주성을 옹호하자,” “로동신문”, 1966. 8. 12.

¹⁰ /Ким Чен Ир. Чучхе сасанэ тэхесо. Пхеньян.1982. с.18/

¹¹ /”Нодун син мүн.1998.8.22/,

¹² Нодун синмүн 2003.3.21/

¹³ /Ким Чер У: Военноориентированная политика Ким Чен Ира, Пхеньян. 2002. С. 3./

¹⁴ СРАВНИТЕЛЬНЫЙ АНАЛИЗ ИДЕЙ ЧУЧХЕ И СОНГУН В КОНСТРУИРОВАНИИ ИДЕОЛОГИИ ВОЕННОГО СОЦИАЛИЗМА В КНДР О.В. Аптеева. Comparative politics.2010.С.226/

тэргүүлэх биш харин үзэл суртал, цэргийн хүчээр засаглалаа хадгалж үлдэх зорилготой болжээ. Эл байдлыг Ким Жон Ир-ийн хэлсэн "үзэл суртлын хувьд хүчирхэг арми, дайснаас дутуу байсан ч ялагдашгүй юм"¹⁵ гэсэн үг ч батална. Ким Жон Ир-ийн үзэл баримтлал гарч ирсэн шалтгааныг БНСУ-ын судлаач дүгнэхдээ, Умард Солонгос хүнсний хямралд гүнзгий орсон нөхцөлд нийгмийн эв нэгдлийг хадгалж, тогтолцоогоо хамгаалахын тулд үзэл санааны хяналт ба "цэргийг түүрүүнд тавих" бодлого цаашид хэрэгтэй болж, үүнтэй холбоотой онолын суурийг тавихын тулд үзэл суртал, цэрэг, улс төрийн бодлогын хүчирхэг улс гэсэн нэрийг гаргаж ирэх хэрэгтэй болсон гэж үзсэн байна.¹⁶

Ким Жон Ир-ийн энэхүү бодлого өнөөг хүртэл түүний хүү Ким Жон Ун-ы ч улс төрийн гол бодлого болж үргэлжилжээ.

Неореализм ба Умард Солонгосын цөмийн зэвсгийн бодлого

Улс төрийн реализмын онолд Х.Моргентау цөмийн зэвсэгтэй орнуудын бодлоготой холбоотой 4 парадоксыг дэвшүүлсэн. 1. Бүх нийтийн цөмийн сүйрлийн улмаас цөмийн зэвсэгтэй орнууд түүнийг хэрэглэхээс эмээх болно, 2. Цөмийн дайны болзошгүй үр нөлөөг зайлуулахын төлөө бодлого явуулах. Энэ нь "хязгаарлагдмал цөмийн дайн" хийх боломжгүйд оршино, 3. Цөмийн зэвсгээр хөөцөлдөхийн сацуу түүнийг зогсоохыг оролдох болно, 4. Холбоотны үүрэг буурч байгаа үед холбоотныг түшиглэх бодлого явуулахыг эрмэлзэнэ. Энэ нь цөмийн зэвсэггүй улсууд цөмийн зэвсэгтэй болсноор бүх нийтийн сүйрэлд хүргэх аюултайд оршино.

Харин неореализмын гол төлөөлөгч К. Уолц "Неореализмын онол дахь дайны эх сурвалж" өгүүлэлдээ цөмийн зэвсгийг энх тайвныг тогтоон барих хүчирхэг зэвсэг, бусад энгийн зэвсгээс илүү улс орнуудыг дайн байлдаанаас зайлсхийхэд хүргэдэг гэж үзсэн.¹⁷ Мөн "Хүйтэн дайны дараах структур реализм" өгүүлэлдээ цөмийн зэвсэг гарсан нь олон улсын харилцааны анарх бүтцийг өөрчлөөгүй боловч зарим улс өөрийн аюулгүй байдлыг хангахдаа бусад улсын аюулгүй байдлыг ч бодолцож байж болох талтай гэж үзжээ.¹⁸ Дараа нь К.Уолц, С.Саган нарын "Цөмийн зэвсгийн дэлгэрэл: шинэ маргаан" номонд, хүйтэн дайны үед аль нэг их гүрний хамгаалалтанд байсан зарим улс, орчин үед аюулгүй байдлаа өөрсдөө хамгаалах шаардлага тулгарсан. Тэдгээр улсын тоонд, Энэтхэг, Пакистан, Ирак, Япон, түүнчлэн УС-ыг оруулжээ.¹⁹ Уолц, цөмийн зэвсэгтэй дэлхий дахинд, Сталин, Мао Цзедун, Ким Жон Ир нарын удирдагчдын хэн нь ч байсан түрэмгийлэл өөрсдийг нь мөхөөх аюултай гэдгээр хандана гэж үзсэн.

БНАСАУ 1980-аад он хүртэл цөмийн хөтөлбөрийг эрчим хүчний зорилгоор

¹⁵ Ким Бон Хо. Видэхан сонгун шидэ. Пхеньян. 2004. тал.23

¹⁶ 주체사상의 형성과 변화에 대한 새로운 분석. 서재진. 통일연구원. 2001. p.113

¹⁷ Waltz K. N. The Origins of War in the Neorealist Theory // The Journal of the Interdisciplinary History. 1988. Vol. 18, No 4 (Spring): The Origin and Prevention of Major Wars. P. 624

¹⁸ Waltz K. N. Structural Realism after the Cold War // International Security. 2000. Vol. 25, N 1 (Summer). P. 5

¹⁹ Sagan S. D. and Waltz K. N. *The Spread of Nuclear Weapons: a Debate Renewed*. New York, W. W. Norton & Company, 2002. p. 110

ашиглаж байгаад 1990-ээд оноос цөмийн зэвсгээр идэвхтэй хөөцөлдөж эхэлсэн. Энэ үеэс Умард Солонгосын цөмийн зэвсэгтэй холбоотой солонгосын хойгийн цөмийн хямрал болж/1992,2002/, 2006 онд Умард Солонгос цөмийн зэвсгийн анхны туршилт хийж, улмаар дараалан хэд хэдэн туршилт явуулж, 2012 оны үндсэн хуулийн нэмэлтэндээ цөмийн зэвсэгтэй улс болохоо тодорхойлсон. Үүнийг дэлхийн хамтын нийгэмлэг эрс буруушааж, АНУ, Өмнөд Солонгос, Япон эрс эсэргүүцэж, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс Умард Солонгосын эсрэг хориг арга хэмжээний тогтоолуудыг удаа дараалан батлан гаргаж ирэв. АНУ нэг бус удаа Умард Солонгост цохилт өгөхөөр бэлтгэж, төлөвлөгөө боловсруулсан. Уолцын, цөмийн зэвсэгтэй ямар ч улс хариу цохилтын болгоомжлолоос болж цохилтоос хамгаалагдана гэсэн үзэл баримтлал²⁰ ч хэрэгжиж байгаа мэт болов. Харин, “Цөмийн дэлхийн” үзэл баримтлалд, цөмийн зэвсэг хүчний тэнцвэрийг хангахад үр нөлөөтэй гэсэн томъёолол яг эсрэг үйлчилгээ үзүүлсэн юм. Умард Солонгос цөмийн зэвсэгтэй болсноор хөрш зэргэлдээ улс орон, юун түрүүнд АНУ-ын шүхэр дор хамгаалагддаг Өмнөд Солонгос, Япон зэрэг орнууд цөмийн зэвсэгтэй болох асуудал хөндөгдөж эхэлсэн ба 2016 онд Д.Трампа АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших үеэрээ хэлсэн үгэндээ, Умард Солонгосын аюул заналхийлэлтэй тулгарсан үед Хятад улс холбоотноо барьж чадахгүй эсвэл хүсэхгүй нөхцөлд Япон, Өмнөд Солонгос цөмийн зэвсэгтэй болсноор асуудлыг шийдэж болох юм гэж²¹ хүртэл мэдэгдэл хийсэн аж. Ийнхүү Умард Солонгосын цөмийн зэвсгийн бодлого ЗХА-ийн бүс нутгийн хүчний тэнцвэрийг хангах гэхээсээ тогтворгүй байдалд хүргэх аюулыг дагуулсан ажээ.

Сүүлийн үед, НҮБ-ын эдийн засгийн хориг арга хэмжээний цар хүрээ улам чангарч, түүнийг нь дэлхийн бүх улс орон биелүүлж, ялангуяа Умард Солонгосын эдийн засгийн гол түнш, холбоотон гэгддэг БНХАУ бүрэн дэмжих болсон нь даяарчлагдсан дэлхийд Умард Солонгосын хаагдмал эдийн засгийг улам хүндрүүлж байгаа тул Умард Солонгост эдийн засгаа хөгжүүлж ард иргэдийнхээ аж амьдралыг сайжруулах эсвэл цөмийн зэвсгээсээ татгалзах гэсэн салаа зам тулгарч байгааг илтгэж байна. Энэ нөхцөлд, БНАСАУ-ын удирдагч Ким Жон Ун АНУ-ын ерөнхийлөгч Д.Трампа-тай дээд хэмжээний уулзалт хийж, цөмийн зэвсгээсээ татгалзахад бэлэн байна гэсэн мэдэгдэл хийж байгаа нь Умард Солонгосын цөмийн зэвсгийн асуудал шийдвэрлэгдэхэд ойртсоныг харуулна.

ДУГНЭЛТ

Ким Ир Сен-ий “Жүчэй”-н онол буюу “бие даах” бодлого нь Өмнөдийг нэгтгэх үндэсний ашиг сонирхлоор илэрхийлэгдэж, чингэхдээ бүх талаар, ялангуяа цэрэг зэвсгийн давуутай болох зорилго нь хүчний дэмжлэгтэй эрх мэдлийн төлөөх тэмцэл байсан бөгөөд Ким Ир Сен-ий энэ бодлогууд нь улс төрийн реализмын

²⁰ *Waltz K. N. The Origins of War in the Neorealist Theory // The Journal of the Interdisciplinary History. 1988. Vol. 18, No 4 (Spring): The Origin and Prevention of Major Wars. P. 615–628.*

²¹ *Donald Trump’s Foreign Policy Speech // The New York Times. April 27, 2016.*

шинж чанартай ажээ.

Харин энэ бодлого 1990 онд дэлхийн социалист систем нуран унаснаар дуусгавар болсон байна. Ким Жон Ир-ийн “цэргийг түрүүнд тавих” бодлого, “хүчирхэг, хөгжилтэй их улсыг байгуулах” үзэл баримтлалуудын үндэсний ашиг сонирхол ба эрх мэдлийн тэмцэл нь тогтолцоогоо хадгалж үлдэх зорилгоор солигджээ.

Умард Солонгосын цөмийн зэвсгийн бодлого нэг талаас цохилтоос хамгаалагдаж байгаа мэт боловч АНУ болон бүс нутгийн их гүрнүүдийн шахалт, НҮБ-ын АЗ-ийн улам бүр чангарч буй эдийн засгийн хориг арга хэмжээнүүд Умард Солонгосын хаалттай эдийн засгийг улам боомилж, цаашид энэ бодлогыг эдийн засаг нь даах тэнхэлгүй болгосоор байна.

Умард Солонгосын цөмийн зэвсгээс татгалзах хамгийн гол парадокс нь орчин үеийн глобалчлагдсан дэлхий ертөнцөд эдийн засгийн хүчин зүйлс улс орны гадаад, дотоод аюулгүй байдлын тэргүүлэх зэргийн баталгаа болсныг илтгэхийн хамт цөмийн зэвсэг дангаараа аливаа улсын аюулгүйн баталгаа болж чадахгүйд оршино. Үүнийг Умард Солонгосын жишээ улам бүр баталсаар байна.

НОМ ЗҮЙ

1. Hans J. Morgentau. Politics Among Nations. The Struggle for Power and Peace. Third Edition. N.Y., 1961 (*перевод М. Старкова*). 1961. P. 27).
2. Маркс и Энгельс. Сочинения. 2-ое издание. Т. 12. С. 735— 736
3. Ким Ир Сен. Об искоренении догматизма и формализма в идеологической работе и об установлении чучхе : Речь перед работниками партийной пропаганды и агитации 28 декабря 1955 года / Ким Ир Сен. — Пхеньян : Инъязиздат, 1973.
4. Ким Ир Сений боловсруулсан “Өөрөө өөртөө эзэн байх” гэсэн гол утга санаатай улс төрийн онол.
5. П.А.Цыганкова. Теория международных отношений: Хрестоматия. 2002. С.72-88
6. БНАСАУ-ын ҮХ, I бүлгийн 4-р зүйл, 1972 он \북한 자료 센터, 통일북한 정보, 북한법령, unikorea.go.kr)
7. “자주성을 옹호하자,” “로동신문”, 1966. 8. 12.
8. /Ким Чен Ир. Чучхе сасанэ тэхесо. Пхеньян.1982. с.18/
9. /”Нодун син мүн.1998.8.22/,
10. Нодун синмүн 2003.3.21/
11. / Ким Чер У: Военноориентированная политика Ким Чен Ира, Пхеньян. 2002. С. 3./
12. Сравнительный анализ идей Чучхе и сонгун в конструировании идеологии военного социализма В КНДР О.В. Аптеева. Comparative politics.2010.С.226/
13. Dae-Sook Suh, *Kim IL Sung, The North Korean Leader*(NewYork: Columbia Univesity Press, 1988), p. 176.
14. Ким Бон Хо. Видэхан сонгун шидэ. Пхеньян.2004. тал.23
15. 주체사상의 형성과 변화에 대한 새로운 분석.서 재 진.통 일 연 구 원.2001. p.113

16. *Waltz K. N.* The Origins of War in the Neorealist Theory // The Journal of the Interdisciplinary History.1988. Vol. 18, No 4 (Spring): The Origin and Prevention of Major Wars. P. 624
17. *Waltz K. N.* Structural Realism after the Cold War // International Security. 2000. Vol. 25, N 1 (Summer).P. 5
18. Sagan S. D. and Waltz K. N. *The Spread of Nuclear Weapons: a Debate Renewed.* New York,W. W. Norton & Company, 2002. p. 110
19. *Waltz K. N.* The Origins of War in the Neorealist Theory // The Journal of the Interdisciplinary History.1988. Vol. 18, No 4 (Spring): The Origin and Prevention of Major Wars. P. 615–628.
20. Donald Trump’s Foreign Policy Speech // The New York Times. April 27, 2016.

